| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,943,597,600.00 | 2,887,060,826.18 | 56,536,773.82 | 98.08 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,943,597,600.00 | 2,887,060,826.18 | 56,536,773.82 | 98.08 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,822,476,000.00 | 2,789,359,296.18 | 33,116,703.82 | 98.83 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,231,547,100.00 | 1,219,423,605.00 | 12,123,495.00 | 99.02 |
| 210101 | Үндсэн цалин | 769,619,300.00 | 733,481,609.00 | 36,137,691.00 | 95.30 |
| 210102 | Нэмэгдэл | 253,012,000.00 | 246,359,527.00 | 6,652,473.00 | 97.37 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 93,810,000.00 | 95,429,162.00 | (1,619,162.00) | 101.73 |
| 210104 | Урамшуулал | 23,392,400.00 | 52,439,907.00 | (29,047,507.00) | 224.17 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 91,713,400.00 | 91,713,400.00 | - | 100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 140,882,500.00 | 131,416,473.18 | 9,466,026.82 | 93.28 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 95,893,300.00 | 89,334,123.97 | 6,559,176.03 | 93.16 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,219,100.00 | 10,167,953.10 | 1,051,146.90 | 90.63 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 9,026,100.00 | 8,528,961.82 | 497,138.18 | 94.49 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,249,500.00 | 1,974,688.73 | 274,811.27 | 87.78 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 22,494,500.00 | 21,410,745.56 | 1,083,754.44 | 95.18 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 187,305,900.00 | 186,138,741.00 | 1,167,159.00 | 99.38 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 27,600,000.00 | 25,241,424.00 | 2,358,576.00 | 91.45 |
| 210302 | Түлш, халаалт | 154,481,900.00 | 155,673,317.00 | (1,191,417.00) | 100.77 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,224,000.00 | 5,224,000.00 | - | 100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 139,047,600.00 | 137,528,080.00 | 1,519,520.00 | 98.91 |
| 210401 | Бичиг хэрэг | 14,899,600.00 | 16,071,850.00 | (1,172,250.00) | 107.87 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 93,500,000.00 | 92,735,600.00 | 764,400.00 | 99.18 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 16,160,000.00 | 15,667,404.00 | 492,596.00 | 96.95 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 500,000.00 | 420,000.00 | 80,000.00 | 84.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 13,988,000.00 | 12,633,226.00 | 1,354,774.00 | 90.31 |
| 2105 | Нормативт зардал | 5,460,000.00 | 5,460,000.00 | - | 100.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 5,460,000.00 | 5,460,000.00 | - | 100.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 35,000,000.00 | 28,541,750.00 | 6,458,250.00 | 81.55 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,000,000.00 | 20,000,000.00 | - | 100.00 |
| 210604 | Урсгал засвар | 15,000,000.00 | 8,541,750.00 | 6,458,250.00 | 56.95 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 81,915,000.00 | 81,783,700.00 | 131,300.00 | 99.84 |
| 210702 | Дотоод албан томилолт | 81,915,000.00 | 81,783,700.00 | 131,300.00 | 99.84 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 322,299,600.00 | 320,542,460.00 | 1,757,140.00 | 99.45 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 314,851,900.00 | 313,224,692.00 | 1,627,208.00 | 99.48 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 1,141,700.00 | 1,011,768.00 | 129,932.00 | 88.62 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 240,000.00 | 240,000.00 | - | 100.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100.00 |
| 210807 | Газрын төлбөр | 1,566,000.00 | 1,566,000.00 | - | 100.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 679,018,300.00 | 678,524,487.00 | 493,813.00 | 99.93 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 645,018,300.00 | 644,824,533.00 | 193,767.00 | 99.97 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 34,000,000.00 | 33,699,954.00 | 300,046.00 | 99.12 |
| 212 | ТАТААС | 43,044,800.00 | 43,044,800.00 | - | 100.00 |
| 2122 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 43,044,800.00 | 43,044,800.00 | - | 100.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 43,044,800.00 | 43,044,800.00 | - | 100.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 78,076,800.00 | 54,656,730.00 | 23,420,070.00 | 70.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 78,076,800.00 | 54,656,730.00 | 23,420,070.00 | 70.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 11,093,100.00 | 17,393,472.00 | (6,300,372.00) | 156.80 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 19,629,900.00 | - | 19,629,900.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 47,353,800.00 | 37,263,258.00 | 10,090,542.00 | 78.69 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,998,597,600.00 | 2,916,241,165.00 | 82,356,435.00 | 97.25 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,943,597,600.00 | 2,866,779,700.00 | 76,817,900.00 | 97.39 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 2,943,597,600.00 | 2,866,779,700.00 | 76,817,900.00 | 97.39 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 55,000,000.00 | 49,461,465.00 | 5,538,535.00 | 89.93 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 55,000,000.00 | 49,461,465.00 | 5,538,535.00 | 89.93 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - | - | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | (0.00) | 0.00 | - |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | ГҮЙЦЭТГЭЛ |
|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,266,320,196.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 2,266,320,196.00 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 2,260,320,196.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 51,190,988.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 51,190,988.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 5,852,847.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 3,958,247.05 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 893,733.42 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 271,356.37 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 51,119.32 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 678,390.84 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 210,462.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 210,462.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,561,783.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 16,561,783.00 |
| 2105 | Нормативт зардал | 12,280,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 9,280,000.00 |
| 210503 | Нормын хувцас зөөлөн эдлэл | 3,000,000.00 |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 121,852,265.00 |

| | | |
|---|---|---|
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 20,593,225.00 |
| 210604 | Урсгал засвар | 101,259,040.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 36,963,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 36,963,800.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 893,738,979.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 893,738,979.00 |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,121,669,072.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,121,669,072.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 6,000,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 6,000,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 6,000,000.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 2,451,631,973.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 2,451,631,973.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөн | 1,496,706,383.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас тосовт тусгагдсан төсвөөс доод шатны төсви | 922,805,823.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орл | 32,119,767.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - |

## 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тус байгууллага нь “Оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар аймгийнхаа хөгжилд дэмжлэг үзүүлж чаддаг, цомхон, чадварлаг , эцсийн үр дүнг эрхэмлэн дээдэлсэн төрийн албыг төлөвшүүлэхэд оршино.” гэсэн эрхэм зорилготой.

Аймгийн ЗДТГазар нь үндсэн 6 хэлтэс, 2 албатай, 74 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж иржээ.

ЗДТГ-ын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй дотоод хяналтын нэгж , 5 хүний бүрэлдэхүүнтэй ёс зүйн хороо , өмч хамгаалах байнгын комисс 5 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж, төлөвлөгөө боловсруулан байгууллагын өмч хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, бараа материалын худалдан авалтад тухай бүр хяналт тавьж ажилладаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил

гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 34,647.0 сая төгрөгөөр *өссөн* байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 00 | 00 | 0 |
| Авлага | 5,339.8 | 3,779.1 | -1,560.6 |
| Бараа материал | 12,913,980.9 | 47,789,595.2 | 34,875,614.3 |
| Үндсэн хөрөнгө | 5,235,701.2 | 5,068,490.1 | -167,211.1 |
| **Нийт хөрөнгө** | **18,249,857.8** | **52,896,864.4** | **34,647,006.5** |
| Өр төлбөр | 550.0 | 0 | -550.0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 18,249,307.8 | 52,896,864.4 | 34,647,556.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **18,249,857.8** | **52,896,864.4** | **34,647,006.5** |

Тайлант хугацаанд мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй гарсан. Авлага 1.6 сая төгрөгөөр буурсан байна. Үлдэгдлээр тайлагнасан 3.8 сая төгрөгийн авлага нь насжилт өндөр, зарим эзэн холбогдогч нар нь тодорхой бус болсон авлага байна.

Урьдчилж гарсан зардал дансанд аймгийн 90 жилийн ойн баримтат кино хийлгэхэд өгсөн 35.0 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг бүртгэсэн байна.

Бараа материал дансны үлдэгдэл 34,875.6 сая төгрөгөөр өссөн нь Аймгийн Засаг даргын захирамжаар 42,483.9 сая төгрөгийн он дамжин хэрэгжсэн аймгийн хэмжээний хөрөнгө оруулалтын ажлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд бүртгэсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө 167.2 сая төгрөгөөр буурсан нь 86.6 сая төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна. Тайлант онд 257.7 сая төгрөгийг элэгдлийн зардлыг бүртгэж, 11.9 сая төгрөгийн гарзыг бүртгэсэнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлдөө орон нутгийн төсвөөс 2,943.6 сая төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 55.0 сая төгрөг, нийт 2,998.6 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, 2,943.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 1,544.5 сая төгрөгөөр *нэмж* тодотгосон байна./Засаг даргын нөөц сан/ Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээнд гүйцэтгэлээр 2,866.8 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, туслах үйл ажиллагааны орлогоос 49.5 сая төгрөгийг оруулж, нийт 2,916.2 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Төсвийн гүйцэтгэлээр 2,887.1 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны зардалд зарцуулж, 28.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,887.1 сая төгрөг буюу 98.0 хувьтай зарцуулагдсан байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 70106-80101-Үндсэн үйл ажиллагааны зардал | 2,381.2 | 2,381.2 | | 100 |
| 2 | 70106-80103-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээ | 1,114.9 | 1,114.9 | | 100 |
| 3 | 70106-80508-Төрийн бус байгууллагад төсвөөс олгох дэмжлэг | 43.0 | 43.0 | | 100 |
| 4 | 70106-80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал, дэмжлэг | 54.7 | 54.7 | | 100 |
| 5 | 70106-81102-Орон нутгийн нөөц хөрөнгө | 1,016.9 | 1,016.9 | | 100 |
| 6 | 70106-82801-Улсын баяр наадам | 659.8 | 659.8 | | 100 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй. Тус байгууллага 2022 онд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 2,451.6 сая төгрөгийн орлого хүлээн авч, бараа үйлчилгээний бусад зардалд 2,260.3 сая төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууалалд 6.0 сая төгрөгийг зарцуулж, 185.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Тус байгууллагад хэрэгжсэн төсөл арга хэмжээ байхгүй.

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | |
| | | | | | | |
| | | | | | | |

## 4.Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Эрдэнэцэцэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/68 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг 75 хувь гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт зардлын дүн 7,007.4 сая төгрөгөөс 1 хувиар буюу 70.1 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагатай холбоотой хуулийн 31 шалгуур үзүүлэлтийг хамааралтай гэж үзэж үнэлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллагын дотор үйл ажиллагаанд ашиглаж байсан 5 автомашиныг Аймгийн ОНӨХ-ээр шийдвэр гаргуулж, ашиглалтаас хасаж шатахууны зардлыг хэмнэжээ.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг үзсэн.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг FAS программд оруулсан мэдээллийн дагуу тухайн байгууллагын шилэн дансны сайтаас мэдээллийг шалгасан.

*Шийдвэрлэсэн нь*:

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай гэж үнэлсэн.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тухайн байгууллагын хувьд бусад нийцлийн асуудлын талаарх хамааралтай асуудал байхгүй байна.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагын 2022 оны эхний хагас жилийн санхүүгийн үйл ажиллагааг хамруулж завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар хэлтэс албадын хэрэгцээнд ашигладаг жижиг оврын суудлын автомашинуудад шатахуун зарцуулахгүй байх 14.2 сая төгрөгийн албан шаардлага, Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах чиглэлээр 84.6 сая төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн.

Албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллажээ.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | **0** | **0** | **0** | **0** | **0** |
| Албан шаардлага | 2 | 150.4 | 2 | 150.4 | 100 |
| Зөвлөмж | 2 | 0 | 2 | 0 | 100 |
| **Нийт дүн** | **4** | **150.4** | **4** | **150.4** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийг үр ашигтай хэмнэлттэй зарцуулж, тухайн байгууллагын үндсэн үйл ажиллагааны зардлаас бусад зардалд төсвийн хөрөнгийг зарцуулахгүй байх.

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2 зөрчил[1] илэрч 6.0 сая төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Тус байгууллага дээр акт гараагүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага гараагүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Авлагын данстай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Төлбөртэй үйлчилгээний авлага дансанд бүртгэлтэй 3.8 сая төгрөгийн авлага нь 3 байгууллагатай холбоотой насжилт өндөр авлага байна.

*Өгсөн зөвлөмж:*

Холбогдох байгууллагуудыг судалж, төлөгдөх боломжгүй болсон нотлох баримтыг үндэслэн найдваргүй авлага дансанд бүртгэх.

2. Тогтмол зардалтай холбоотой асуудал

*Илрүүлэлт:*

Түлш халаалтын зардлаас гэрэл цахилгааны зардалд 2.2 сая төгрөгийг шилжүүлсэн байна.

*Өгсөн зөвлөмж:*

Хуваарилагдсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 6 дугаар сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

Санхүүгийн тайлангийн аудитаар залруулга гараагүй.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хуваарилагдсан зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй байна. | 1 | 2217.6 | | | | | 1 | 2217.6 | | | | |
| Насжилт өндөр авлагыг шийдвэрлэх | 1 | 3779.1 | | | | | 1 | 3779.1 | | | | |
| Дүн | 2 | 5996.7 | | | | | 2 | 5996.7 | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР